



***БУФЕР, ТҮҮНИЙ ТӨРӨЛ, ТАВИГДАХ
ШААРДЛАГА***

*Г.Батсайхан
Ж.Бөртэ - Үжин*

АГУУЛГА

- *Зориулалт, ажиллах зарчим*
- *Буферын төрөл, ангилал*
- *Тавигдах шаардлага*
- *Суурилуулалт*



БУФЕРЫН ЗОРИУЛАЛТ


Буфер нь лифтний бүхээг болон эсрэг ачааны доор суурилагдах бөгөөд энэ нь лифтний хязгаарын таслагчууд ажиллаагүй нөхцөлд бүхээг эсрэг ачааны шилжилтийн энергийг сарниулж, тулах цэг болж өгснөөр, дээш шилжиж байгаа хэсгийг нь хонгилын оройг мөргөхөөс хамгаалдаг



БУФЕРЫН АЖИЛЛАХ ЗАРЧИМ

- *Буфер дээр цохих ажиллагааны үед бүлүүр /поршень/ 2 нь дотор цилиндр 1 руу шахагдаж орно. Энэ үед цилиндр дэх ажлын шингэн 3 нь шахагдан түүний жижиг нүхээр 4 гарч гадна цилиндрт 5 орно. Үүнтэй зэрэгцэн, том цилиндрийн дээд хэсэгт байх хийн орчин 6 шахагдана. Хатуу хром гадаргуутай бүлэгч штанг нь нягтруулагчаар 7 найдвартай битүүмжлэгдэнэ.*
- *Буфер дээрх ачааллыг авсны дараа, ажлын шингэн нь шахагдсан хийн даралтаар шахагдсан дотор цилиндр буцан орно. Үүнээс улбаалан, бүлэгч штанг нь дээш шилжинэ. Бүлэгч штанг бүрэн дээшилсэн үед ажлын шингэний түвшинг буферыг нээлгүйгээр харах шилээр 9 гаднаас нь шалгах боломжтой.*
- *Буферыг шилжиж эхлэх үед хязгаарын таслагч 13 салах ба энэ нь буферын бүлүүртэй түлхэгчээр 10 холбогдоно. Бүлүүрийн дээд талд цохилтыг зөөллөх зориулалттай резинэн хавтан 16 байна.*
- *Ашиглалтын явцад ажлын шингэнийг дээд нүхээр 14 нэмэх буюу юүлэх ба хэт их ачааллын үед хийн хавхлага 15 нээгдэн буферын эд ангийг хамгаална.*





БУФЕРЫН ТӨРӨЛ

Буферыг хийцээр нь дараах хэдэн төрөлд хуваадаг.



пүрштэй



гидравлик



холимог



цул



Буферийг энергийг сарниулах байдлаар нь:

- *Шугаман шинж чанартай, энергийг сарниулах /Шингэнт буфер/*
- *Шугаман бус шинж чанартай, энергийг хуримтлуулах /Пүршт, холимог, полиуретан буфер/*



БУФЕРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

Шугаман шинж чанартай буферын хувьд:

- *Буфер нь лифтний хурдыг 15% ихэсгэсэн хурдыг зорчигчид нөлөөлөхгүйгээр зогсоохоор хийгдсэн байна. Үүний тулд хурдатгалыг их байлгахгүй тулд түүний агших хэмжээ багагүй байх ёстой. Буферийн агших хамгийн бага хэмжээ нь 65 мм байна. 4 м/с-ээс их хурдтай буферын агших хэмжээ 540 мм-ээс бага байж болохгүй*
- *Буфер дээр буух ачааллыг тооцохдоо бүхээгийн нийт массыг 2.5-аас 4 дахин үржүүлсэн хэмжээгээр авна.*
- *Буферт аюулгүй таслагч тавьж өгнө*
- *Гидро буферт шингэний төвшинг шалгаж байх цонх хийсэн байх ёстой*



Шугаман бус шинж чанартай буферын хувьд:

- Чөлөөт уналтын тохиолдолд, бүхээг нь бүхээгийн буферийг тооцоолсон хурдны 115%-тай тэнцэх тооцоолсон ачаалал ба хурдтайгаар мөргөхөд, дундаж хурд бууралт нь $1 g_n$ -ээс их байх ёстой. g_n – чөлөөт уналтын хурдатгал (9.81 м/сек^2)*
- $2.5 g_n$ -ээс илүү хурд бууралт нь 0.04 сек-ээс илүү удаан үргэлжилж болохгүй.*
- Буферийн буцах хурд нь 1 м/сек -ээс хэтэрч болохгүй.*
- Бүхээг болон эсрэг ачаа нь буфер дээр ирсний дараа буцахгүй гацаж болохгүй.*
- Буферийн өндөр 90% хүртэл шахагдсан бол түүнийг бүрэн шахагдсан гэж үзнэ.*



ХУДАГТ БУФЕР УГСРАХ

Зам төмрийн суурин дээр буферийг байрлуулж болтоор бооно. Суурь төмрийн тэгшийн алдаа нь 3мм-ээс хэтрэхгүй байна. Буферийн өндрийн эгц босоо байдлыг дүүжин утсаар шалгах ба алдаа нь 100мм-т 1мм-ээс хэтрэхгүй байна. Суурь төмрийн доогуур ба бүх тал руу нь 10-15 см илүү гарган бетон цутгана.



*АНХААРАЛ ТАВЬСАН ТА БҮХЭНД
БАЯРЛАЛАА*

